

	ны өдрийн "Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөр батлах тухай" 56 дугаар тогтоолын хүрээнд өөрсдийн эзэмшил газарт бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх, хайс хашааг ургамлан хашлага болгох		
2.4.2	Бүх нийтээр мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тарьсны дараах усалгаа, арчилгаа, хамгаалалтад анхаарч ажиллах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорноговь-80 цогцолборын ногоон байгууламж бүхий төгөл хэсэгт 2025 оны 05 дугаар сард 50 ширхэг мод тарих ажлыг нийт албан хаагчид зохион байгуулсан. Сумдын газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөнд нийт 2 байршлын 24.56 га талбайд ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Төлөвлөгдсөн ногоон байгууламжийн орон зайн мэдээллийг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д бүртгэсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 1 нэгж талбарын 19.56 га газрыг олгосон.	100
2.4.3	Байгууллагын өрөө тасалгааг цэцэгжүүлж ногоон орчин бүрдүүлэх	Байгууллагын өрөө тасалгааг цэцэгжүүлж ногоон орчин бүрдүүлсэн.	100
2.5	Нийгмийн бодлогын салбарын хүрээнд		
2.5.1	Монгол хэлний тухай хуулийн дагуу 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр (хосолсон хэлбэрээр) хөтлөн явуулах хэрэгжилтийг хангах, ажилтан, албан хаагчдыг үндэсний бичигт сургах, үндэсний бичгийн булантай болох	Тус байгууллага нь уг хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс байгууллагын албан бланкны эх загварыг батлуулан хэвлүүлсэн. Албан хаагчдын компьютерт монгол бичгийн гарын драйвер суулгаж, үндэсний бичгийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлсэн. Мөн хос бичгийн гэрээт ажилтан авахаар сонгон шалгаруулалт явуулахаар төлөвлөгөөндөө оруулан ажиллаж байна.	100
2.5.2	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Англи хэлтэй Дорноговь" зорилтот	Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулан баталж, бие даан суралцах боломжоор ханган ажилласан.	100

	хөтөлбөрийг хэрэгжүүлэн, албан хаагчдын англи хэлний түвшинг ахиулах арга хэмжээг зохион байгуулах;		
2.5.3	"Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, шинжилгээ"-нд албан хаагчдыг бүрэн хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тодорхой давтамжтай хамруулах	Урьдчилсан үзлэг, шаардлагатай эмнэлгийн оношилгоонд хамрагдах албан хаагчдын тоог , хамтран ажиллах байгууллагын мэдээлэл , хуваарийг судалж байна.	100
2.5.4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө" болон төсвийг баталж, хуулийн 17, 27, 28, 29 дүгээр зүйлд заасны дагуу тодорхой ажлуудыг бодитой зохион байгуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлд тайлагнах	ХББОССайд, ГБХНХСайдын 2025.05.06-ны өдрийн 100/А101 дугаартай хамтарсан тушаалаар "Аюулгүй барилга-аюулгүй ажиллагаа" аяныг 2025.05.06-наас 2025.06.30-ны өдрийг хүртэл хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд аймгийн ГХБХБГ, ХХҮГ хамтран "Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал" сэдэвт сургалтыг 2025.05.28-ны өдөр зохион байгуулсан. Сургалтаар барилгын салбар дахь үйлдвэрлэлийн осол, учирч болох аюул ослоос урьдчилан сэргийлэх, барилга угсралтын ажлын чанар болон барилгын материалыг лабораторийн шинжилгээнд хамруулахад анхаарах асуудлын талаар оролцогчдод мэдлэг олгож, мөн салбарт шинээр батлагдсан "Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм /БНБД 12-02-24/"-ийг танилцуулсан. Сургалтаанд нийт 28 аж ахуйн нэгжийн захирал, инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг хамруулсан.	100
2.5.5	Хөдөлмөрийн тухай хуулийн 144, 145 дугаар зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байраар хангах хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааг авахаар холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлсэн.	30

2.5.6	Байгууллагын “Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг”, эцэг, эхийг зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүлийн мэдээллийн сан бүрдүүлж, гэр бүлийн боловсрол олгох, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээ авах, хүүхдийн өрөө тохижуулах, өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах зэргээр эцэг эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс 2025 онд хийх ажлыг төлөвлөгөөг төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сайншанд сумын Дорноговь-80 цогцолбор цэцэрлэг хүрээлэнд байгууллагын албан хаагчдын санаачилгаар хүүхдэд эрсдэл үүсгэж болзошгүй чанарын шаардлага хангахгүй, эвдэрч гэмтсэн тоглоомуудыг шинэчлэн, тоглоомын талбайг цэвэрлэх, будгийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100
2.5.7	Албан хаагчдын хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих, ажлын байрны дасгал тогтмол хийлгэх, үндэсний өв соёл, спортын төрлүүдийг хөгжүүлэх, сурталчлах, байгууллагын шинээр томилогдсон болон залуу албан хаагчдыг дадлагажуулах, ур чадварыг сайжруулах, ажлын байрандаа хөгжих боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах	Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, нийгмийн идэвхийг дээшлүүлэх зорилгоор 7 хоног бүрийн Мягмар гаригт спорт зааланд тоглуулахад шаардагдах зардлыг асуудлыг шийдвэрлэж албан хаагчдыг хамруулан ажиллаж байна.	100
2.6	Салбарын зорилтын хүрээнд		
2.6.1	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль, Татварын тухай хууль, Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, холбогдох дүрэм журам, Засгийн газрын тогтоол, Шадар сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагын гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн	Аймаг, сумдын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаа, бэлчээрийн фото мониторингийн судалгааны ажлыг жил бүр зохион байгуулж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, аймаг, сумдын шинэчлэх шаардлагатай газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэн, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтыг	100

	хэрэгжүүлэх үүрэг хүлээж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна	холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, холбогдох саналаа боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах арга хэмжээ авч, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зохих мэдээ мэдээллийг нэгтгүүлж ажиллаж байна.	
2.6.2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр хамтран ажиллах бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгууллагын болон төсвийн үйл ажиллагааг ил тод болгох	Нийтийн мэдээллийн цахим хуудас болох www.shilen.gov.mn -д хуульд заасан мэдээллүүдийг улирал тутам шинэчлэн байршуулах ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж байна. Үүнд байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалт, хүний нөөц, гүйцэтгэл, тайлан зэрэг мэдээллүүдийг улирал бүр шинэчлэн бүрэн оруулж байна.	100
2.6.3	Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргээ хуульд заасны дагуу биелүүлэх талаар хуулийг таниулах ажлыг эрчимжүүлж, иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн дарга, эрхлэгчид, ажиллагсдад салбарын хууль тогтоомжийн хүрээнд мэдлэг боловсрол олгох ажлыг зохион байгуулах	Барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалтыг Салбарын хяналтын газрын даргын баталсан 02-00/05 тоот удирдамжийн хүрээнд сургууль цэцэрлэгийн 3, орон сууцны 6, соёл спортын -2, эмнэлэгийн 1, худалдаа үйлчилгээ болон бусад чиглэлийн 3 барилга байгууламжийн угсралтын ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг захиалагч, зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудын ИТА болон бусад төлөөллийг байлцуулан хийж, илэрсэн зөрчил дутагдлыг хэрхэн арилгах цаашид авах арга хэмжээний талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Харин Сайншанд сумын 5 аж ахуйн нэгжид газар, геодези, зураг зүйн чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг 05 сарын 26-наас 06 сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэж байна. Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай" албан даалгаврыг Дорноговь аймгийн 14 сумын Засаг дарга, сумын ЗДТГ-т, СӨХ-ний холбоо, Зураг төслийн 2 компани, 3-н ханган нийлүүлэгч байгууллагад албан бичиг төлөвлөн хүргүүлж ажилласан.	100

2.6.4	Барилгын норм ба дүрэм, техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, түүхий эд, материалын бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр гадаад, дотоодын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг нэмэгдүүлж, тус салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 49173-003-MON" төслийн хүрээнд Эрдэнэ суманд Эрүүл мэндийн төвийн барилга барих ажлыг 4437.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Бако констракшн" ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажил дуусч заслын ажил хийгдэж байна. Ажлын явц 85%-тай. Эмнэлгийн барилгын ажлын явцад тус газраас захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төвтэй хамтран хэрэгжүүлж ажилласан.	100
2.6.5	Барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллах	<p>- Тус газраас эхний хагас жилийн байдлаар улсын болон орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд шинээр хэрэгжих 36.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 барилга байгууламж, ЦДАШ-ын угсралт, их засвар, гадна тохижилтын ажлын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан. Мөн он дамжин хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийн хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Захиалагчийн хяналтын инженерүүд үе шатны ажлын явцад графикийн дагуу захиалагчийн хяналтыг тавьж, ил далд ажлын актыг баталгаажуулан, барилгад ашиглагдаж буй материалыг тус газрын дэргэдэх барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулж ажилласан. Захиалагийн хяналтын мэдээ, тайланг АЗДТГ-ын БОНХОБТХ-т сар бүр хүргүүлэн ажилласан.</p> <p>- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" болон аймгийн Засаг даргын 2021 оны 212 дугаартай захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн нь эхний хагас жилд аймгийн хэмжээнд шинээр баригдсан 12 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.</p> <p>- Тус газрын барилгын материалын лаборатори нь эхний хагас жилийн байдлаар нийт 23 аж ахуйн нэгж, иргэний нэр давхардсан тоогоор 87 удаагийн 350ш дээжийг хүлээн авч, бүртгэлжүүлэн сорилт, шинжилгээг хийж, баталгаажуулсан.</p>	100

		<p>Нийт ирсэн дээжийг дотор нь задалбал:</p> <ul style="list-style-type: none"> - Бетон сорьц /10x10x10см/ - 306 ш - Бетон сорьц /15x15x15см/ - 9 ш - Тоосго – 5 ш - Хөөсөн полистрол хавтан – 3 ш - Элс – 6 ш - Дайрга – 10 ш - Хөнгөн бетон – 10 ш - Явган замын хавтан- 1ш 	
2.6.6	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд боловсруулагдаж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах үйл явцад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдийн саналыг авч тусгах ажлыг хэрэгжүүлнэ.</p>	<p>2025 онд аймаг, сумын орон нутгийн төсвийн нийт 11450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 сум /Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Хөвсгөл, Сайхандулаан, Улаанбадрах, Эрдэнэ/-ын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2 сум /Айраг, Сайхандулаан/-ын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн ба Алтанширээ, Даланжаргалан, Хөвсгөл, Улаанбадрах , Эрдэнэ, Сайхандулаан сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах цахим тендерт мэргэжлийн эрх бүхий байгууллага Циркулпреокт ХХК, Айраг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Газар дэлхий" ХХК, Сайхандулаан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Ланд овнер" ХХК шалгарч тус тус гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна.</p>	100
2.6.7	<p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах</p>	<p>2025 онд аймаг, сумын орон нутгийн төсвийн нийт 11450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 сум /Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Хөвсгөл, Сайхандулаан, Улаанбадрах, Эрдэнэ/-ын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2 сум /Айраг, Сайхандулаан/-ын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, ажлын даалгаврыг боловсруулан БХБЯ, ГЗБГЗЗЕГазраар тус тус хянуулан батлуулж, тендер зарлуулахаар холбогдох материалыг аймгийн Худалдан авах ажиллагааны Газар, сумдын ЗДТГазарт хүргүүлсэн. Одоогоор Алтанширээ, Даланжаргалан, Хөвсгөл, Улаанбадрах , Эрдэнэ, Сайхандулаан сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах цахим тендерт Циркулпреокт ХХК шалгарч, гэрээ байгуулан суурь судалгааны ажлыг эхлүүлсэн бол Иххэт, Дэлгэрэх сумдын хот хөгжлийн</p>	100

		<p>ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт явагдаж байна.</p> <p>Харин Айраг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Газар дэлхий" ХХК, Сайхандулаан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Ланд овнер" ХХК шалгарч тус тус гэрээ байгуулсан.</p>	
2.6.8	Аймаг, сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн дахин төлөвлөлт хийж, орон сууцны цогцолбор хороолол барих бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	<p>Эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 1135 айлын 20 орон сууцны барилгад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас хяналт хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал: Сайншанд сумын 3 дугаар багт "Энержи парагон" ХХК-ийн барьж буй 10 давхар 134 айл /67*2ш/ -ын 2 блок орон сууцны барилгын явц 55%-тай, 7 дугаар багт "Гантулга трейд" ХХК-ийн барьж буй "Мандах наран" хорооллын 288 айл /72*4ш/ -ын орон сууцны барилгын явц 35%-тай, Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт "Гантулга трейд" ХХК-ийн барьж буй 288 айл /72 айл*4 блок/-ын орон сууцны барилгын явц 95%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа бөгөөд барилгын техникийн хяналт 2-оос доошгүй удаа хэрэгжүүлж шаардлага, зөвлөмж өгч ажилласан. Шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудын газрыг хот хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан олгож, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар болон ажлын зургийг хянахдаа хот төлөвлөлтийн норм стандартад нийцүүлэн баталсан.</p>	100
2.6.9	Дорноговь аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх	<p>Аймгийн ИТХурлын 2025 оны 04/07 дугаар тогтоолоор Мандах, Хөвсгөл, Хатанбулаг суманд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам дагуу 7 байршилд нийт 1579.5 га газрыг үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан.</p>	100
2.6.10	Сайншанд, Замын-Үүд сумдын үерийн усны далан шуудууг нэмэгдүүлэх, сэргээн засварлах ажлын тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, үе шаттай хэрэгжүүлж болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ авах	<p>-Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2025.06.25-ны өдөр Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хамтарсан ажлын хэсэг Сайншанд сумын нутаг дэвсгэрт байрлах үерийн далан сувгийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээний байдалд хяналт шалгалт хийж холбогдох газруудад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажилласан.</p> <p>-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын батласан 2025.02.18-ны өдрийн 2025/02 дугаартай "Шар усны болон уруйн, хур борооны үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай"</p>	100

		<p>албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд сумын Засаг дарга нарт үерийн эрдлээс урьдчилан сэргийлэх, далан сувгийн цэвэрлэгээний ажлыг тогтмолжуулах чиглэлээр тус газрын 2025 оны 147 тоот албан бичгийг хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан.</p> <p>- Сайншанд сумын хэмжээнд үерийн ус зайлуулах инженерийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 299.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гидродизайн инноваци" ХХК гүйцэтгэж байна. Инженер техникийн судалгаа, хэмжилт, нарийвчилсан судалгааны инженер геологийн хайгуул, геодези байр зүйн тоон зураглалын ажил бүрэн дуусч, холбогдох төлөвлөлт, гидравликийн тооцоог гүйцэтгэж, зураг төслийн трассыг гаргаж дуусган боловсруулалтын ажил хийгдэж байна.</p>	
2.6.11	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэх	<p>- Тус газраас эхний хагас жилийн байдлаар улсын болон орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд шинээр хэрэгжих 36.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 барилга байгууламж, ЦДАШ-ын угсралт, их засвар, гадна тохижилтын ажлын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан. Мөн он дамжин хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийн хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Захиалагчийн хяналтын инженерүүд үе шатны ажлын явцад графикийн дагуу захиалалагчийн хяналтыг тавьж, ил далд ажлын актыг баталгаажуулан, барилгад ашиглагдаж буй материалыг тус газрын дэргэдэх барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулж ажилласан. Захиалагийн хяналтын мэдээ, тайланг ЗДТГ-ын БОНХОБТХ-т сар бүр хүргүүлэн ажилласан.</p>	100
2.6.12	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж буй иргэдэд холбогдох хууль, журмын дагуу газар эзэмшүүлэх, ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэх, мэдээ, мэдээллээр хангах	Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр газартай холбоотой аливаа хүсэлтийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр хүлээн авах, өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэхээр хуульчилж, газрын удирдлагын нэгдсэн системд хөгжүүлэлт хийгдсэн тул дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон.	-

2.6.13	Дорноговь аймгийн Засаг дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай 2025 онд хамтран хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний заалт тус бүрийг үр дүнтэй хэрэгжүүлэх	Дорноговь аймгийн Засаг дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай 2025 онд хамтран хэрэгжүүлэхээр байгуулсан 23 заалт гэрээний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргаж БОНХОБТХ-т хүргүүлсэн.	100
2.6.14	Аймгийн хэмжээнд салбарын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр сумд, холбогдох газруудтай хамтран ажиллах	"Төрийн албан хаагчийн ажиллах, нөхцөл,нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2025 оны төлөвлөгөөг" боловсруулан Газрын даргын А/04 тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг хагас жилийн байдлаар гарган тус газрын 2025 оны 401 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. Говийн бүсийн анхдугаар зөвлөгөөн Дорноговь аймагт зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн ерөнхий газрын удирдлагууд тус газрын үйл ажиллагаатай танилцаж, аймгийн нийт албан хаагчидтай уулзалт хийсэн. Тус уулзалтаар албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх хүсэлт тавьсан.	100
3.2	Байгууллагын удирдлагын хүлээх үүрэг		
3.2.1	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн хамтран ажиллах чиг үүрэг, үндсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцах	Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус байгууллагатай холбоотой 26 арга хэмжээ, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах 9 зорилт бүхий 29 арга хэмжээний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг гаргаж тус байгууллагын 2025 оны 342, 376 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажилласан.	100
3.2.2	Салбарын төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, олон улсын төсөл, хөтөлбөрөөс хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөл, арга хэмжээ, санхүүгийн дэмжлэг авах, үр дүнг	2026 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх 2 арга хэмжээний саналыг ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн.	100

	тухай бүр танилцуулах		
3.2.3	Шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг үр дүнтэй, хүртээмжтэй, арга хэлбэрээр ялангуяа техникийн дэвшлийг ашиглаж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх	Шинээр батлагдан гарсан 4 журам, аргачлалыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулсан.	100
3.2.4	Монгол Улсын хууль тогтоомж, хариуцсан үйл ажиллагаагаа сурталчлах, тайлагнах, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр иргэдийг тасралтгүй хангах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх замаар сэтгэл ханамжийн баталгааг хангах арга хэмжээ авах	Байгууллагын вэб хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр салбарын цаг үе, үйл ажиллагаатай холбоотой 243 мэдээлэл орж уг мэдээллийг өдөрт дунджаар 316 хүн хандаж үзэж байгаа нь сард 9480, өнөөдрийн байдлаар өссөн дүнгээр 56880 хүн байгууллагын вэб хуудаснаас мэдээ мэдээлэл авсан ба иргэдийн зүгээс эерэг сэтгэгдэл, "хялбар болсон" гэх сэтгэгдэл ирсэн байна.	100
3.2.5	Авлигаас ангид, сайн засаглалын төлөөх үйлчилгээг бий болгох талаар бодитой ажил төлөвлөж, үр дүнгээ тооцох, бусдад сайн туршлага болохуйц үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны А/06 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар гаргаж ГЗБГЗЗЕГ азарт хүргүүлсэн	100
3.2.6	Төрийн үйлчилгээний шинэ менежмент болон иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг үзүүлэх замаар мэдээлэл түгээх шинэ загваруудыг нэвтрүүлж, төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчид нь сахилга, ёс зүйгээрээ байгууллага, албан хаагчдаа манлайлж ажиллах	Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, иргэн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, нэгдсэн ойлголтод хүрэх хамтарсан уулзалтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй 2025 оны 05 сард зохион байгуулж, үл хөдлөх эд хөрөнгөд гэрчилгээ олгох, Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөн, Хаягийн асуудал зэргээр харилцан санал солилцож, төрөөс үзүүлж буй үйлчилгээнд гарч буй хүндрэл чирэгдэлтэй холбоотой асуудалд нэгдсэн ойлголтод хүрч, төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх арга хэмжээг цаашид бүсчилсэн хэлбэрээр тогтмол хамтран зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.	100